



“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН РОЖЕР ТОМАС МОЕЭСИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН”

Миний бие Рожер Томас Моеэс нь Монголбанкны 2022.09.14-ны өдрийн А-1/981 албан бичгийн зөвшөөрлийн дагуу Богд Банк ХК-ийн ТУЗ-ын Хараат бус гишүүнээр томилогдож одоогоор ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшигүүлэх, үнэлгээ урамшууллын хорооны гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүнээр тус тус ажиллаж байна.

/ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРМЫН 5.2.1, 5.2.2/

Тайлант хугацаанд ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллаж журмын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1. Аудитын хорооны гишүүн:

Тус хорооны 2023.02.08 болон 2023.05.22-ны 2 удаагийн ээлжит хуралд оролцож дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Дотоод аудитын жилийн төлөвлөгөө, түүний биелэлт, Дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэлийн тайлан, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх, дараа оны төлөвлөгөөг хэлэлцэх, батлах тухай
- Банкны дотоод аудитын бодлого, дотоод аудиттай холбоотой заавар, журмуудын төсөл, журмуудад орох нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хэлэлцэж өөрийн саналаа өгч ажилласан.

Аудитын хорооны гишүүний хувьд Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д компанийн дотоод болон хөндлөнгийн аудит, дотоод хяналтын систем, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлан, ёс зүйн дүрэм, хууль журмын хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, аудитын үйл ажиллагааны үр дүнг Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д мэдээлэх, банкны удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд байгууллагын сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэн ажиллаж байна.

2. Нэр дэвшигүүлэх, үнэлгээ урамшууллын хорооны гишүүн

Тус хорооны 2 удаагийн хуралд оролцож дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Үүнд:

- Банкны Гүйцэтгэх удирдлагын ажлыг дүгнэх, үнэлэх ажиллагаанд оролцож Банкны 2022 оны санхүүгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөний хэрэгжилттэй дэлгэрэнгүй танилцаж Санхүүгийн болон бусад үзүүлэлтийг харгалзан үзэж Гүйцэтгэх захирал Г.Саруулын 2022 оны ажлын гүйцэтгэлийг дүгнэн хэлэлцсэн.
- Хорооны ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшигүүлэх, үнэлэх үйл ажиллагааны чиглэлийн дагуу 2023.03.10-ны өдөр ТУЗ-д шинээр гишүүн томилох, мөн хүсэлтээ өгсөн ТУЗ-ийн гишүүний хүсэлтийг хүлээж авах асуудлыг хорооны гишүүдтэй хэлэлцэж хурлаас гарсан дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулахаар өөрийн саналыг өгч ажилласан байна.

3. ТУЗ-ийн хурал

2023 оны эхний хагас жилийн байдлаар ТУЗ-ийн нийт 35 удаагийн хуралд оролцсон ба уг хурлуудаар Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшигүүлэх, томилох, чөлөөлөх журмын 5.2.3 дахь заалтын дагуу Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах, БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасны дагуу дараах хурлуудад оролцсон байна.

2023.02.01-ний Кредит картын эрхийн нэмэгдүүлэх тухай

2023.03.17-ны Зөвлөх үйлчлгээний гэрээ байгуулах тухай



2023.04.05-ны Зээл олгох тухай болон Түрээсийн гэрээ байгуулах тухай

2023.05.11-ний Зээл олгох тухай хэлцлүүдэд оролцож санал өгч ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна. Мөн Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэрийг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс гаргаагүй болно.

4. Хараат бус гишүүний хувьд:

Хараат бус гишүүний чиг үүргийн дагуу хороодын ажлын чиг үүргийн хүрээнд холбогдох нэгжүүдтэй ойрхон ажиллаж, энэ чиглэлээр ТУЗ болон Банкны удирдлагад зөвлөмж өгч ажиллаж байна.

Банкны засаглал хэвийн сайн хэрэгжиж байгаа. ТУЗ ба удирдлагын багийн зүгээс, Банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх ноцтой үйлдэл, шийдвэр ажиглагдаагүйг тэмдэглэж байна.

Цаашид Монголбанкны "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 5 дугаар заалтын дагуу өөрийн хариуцаж байгаа өөрийн хийж гүйцэтгэсэн ажлыг журмын дагуу хариуцлагатайгаар гүйцэтгэж тайлагнан ажиллах болно.

Богд банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2023.07.06

/Рожер Томас Моеэс/